ХУУЛЬ ЗҮЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫГ 10 ДАХЬ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА 2

“ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХААЛТЫН АРГА ХЭМЖЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА 4

“ЯПОН УЛС БА МОНГОЛ УЛСАД ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСЫГ ТӨЛӨВШҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ХУРАЛ БОЛЛОО 5

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Эрх чөлөөтэй байхын тулд хуульд захирагдах хэрэгтэй*
*Ж.Амарсанаа*

# Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn | Хууль зүйн мэдээ сонин | 2022.12.30

## ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ







## ГЭР БҮЛИЙНТУХАЙ ХУУЛЬ









## ХУУЛЬ ЗҮЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫГ 10 ДАХЬ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн хуульчдад хууль зүйн англи хэлний бичгийн болон бусад чадвараа хөгжүүлэхэд нь түлхэц үзүүлэх, арга барилаа олоход нь чиглэл өгөх зорилгоор 2012 оноос эхлэн Хууль зүйн англи хэлний сургалтыг зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтыг 2022 оны 11-р сарын 1-нээс 29-ний өдрийг дуустал зохион байгуулсан ба 42 хүн хамрагдаж, хууль зүйн бичлэг (Legal writing)-ийн хэв маяг, арга техникийн үндсэн ойлголтыг авч, англи хэлний хууль зүйн нэр томъёоны хэрэглээ, орчуулах арга зүйд суралцлаа.

ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D.,) С.Сүхбаатар, МУИС-ийн ХЗС-ийн багш, (LL.M.) Э.Туулайхүү нар тус сургалтын багшаар ажиллаж, Хууль зүйн англи хэлний онцлог, хууль зүйн орчуулга хийх техникүүд, Хууль, гэрээ зэрэг эрх зүйн албан ёсны баримт бичиг болон эрх зүйн бусад бичвэр орчуулах арга зүй, Гэрээний эрх зүй, Компанийн эрх зүй, Олон улсын худалдааны эрх зүй, Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй, Маргаан шийдвэрлэх, Өмчийн дүрэм, Хариуцлагын дүрэм зэрэг сэдвээр эрчимжүүлсэн сургалт явуулав.

2022 оны 11 сарын 29-ний өдөр тус сургалтад амжилттай хамрагдсан суралцагчдад СЕРТИФИКАТ гардууллаа.








## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт”-ыг Хөвсгөл аймагт 12 дугээр сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн ухааны доктор /PhD/, профессор Э.Батбаяр, Хууль зүйн ухааны доктор /PhD/, дэд профессор А.Алтанзул, Ахлах багш С.Ганцэцэг, ХЗҮХ-ийн сургалт хариуцсан мэргэжилтэн П.Аззаяа нар хичээл заав. Хөвсгөл аймгийн 50 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.












## “ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХААЛТЫН АРГА ХЭМЖЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2012-2022 онд хэрэгжүүлсэн “Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр”-ийн хаалтын арга хэмжээ болж үр дүнгийн хэлэлцүүлэг хийлээ. Хөтөлбөрийн хүрээнд Хотын засаглалыг сайжруулах, Төвлөрлийг сааруулах, Иргэдийн оролцоог хангах гэсэн үндсэн 3 чиглэлд анхаарч төсөл хэрэгжүүлсэн.

Төлийн хаалтын үйл ажиллагааны үеэр салбар төслүүд өөрсдийн үйл ажиллагааны үр дүнг танилцуулж, сургамж, туршлагаа хуваалцаж, үр дүнгийн цаашид тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар хэлэлцлээ.

Уг хөтөлбөрийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран “Иргэдийн оролцоо” төслийг 2015-2022 оны хугацаанд хэрэгжүүлж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн тус хөтөлбөрийн хүрээнд “Иргэдийн оролцоо” төсөлтэй хамтран хэрэгжүүлсэн ажил, эрхлэн гаргасан ном гарын авлагын тайлан зэргийг дэлгэн танилцууллаа.











## “ЯПОН УЛС БА МОНГОЛ УЛСАД ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСЫГ ТӨЛӨВШҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ХУРАЛ БОЛЛОО

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Япон Улсын Хууль зүйн яам хамтран хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд өнөөдөр /2022.12.16/ “Япон Улс ба Монгол Улсад хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэн хөгжүүлэх нь” сэдэвт хурлыг зохион байгууллаа.

Хурлыг нээж Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Япон Улсын Хууль зүйн дэд сайд Хироаки Кадояма болон Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хироюки Кобаяши нар мэндчилгээ дэвшүүлэв.

Хурлын үеэр “Япон Улс ба Монгол Улсад хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, хөгжүүлэх нь” сэдвийн хүрээнд Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал доктор профессор Б.Амарсанаа тэргүүтэй илтгэгч нар илтгэл тавин оролцсон ба Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, доктор Х.Эрдэм-Ундрах хурлыг хааж үг хэллээ..







## “ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА









## БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН VI ХУРАЛДААН БОЛЛОО

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний зөвлөл”-ийн ээлжит хуралдаан өнөөдөр /2022.12.20/ боллоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний зөвлөлийн дарга Х.Нямбаатар хуралдааныг нээж хэлсэн үгэндээ 2022 онд хийж хэрэгжүүлсэн онцлог ажил, арга хэмжээнээс дурдсан юм.

Тухайлбал, улсын хэмжээнд нийт 1900 орчим эрх зүйн хөтчийг шинээр бэлтгэж, 600 гаруй эрх зүйн хөтчийг чадавхжуулсан бөгөөд эдгээр эрх зүйн хөтөч нь 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажилласан.

ХЗҮХ-ээс ажиллуулдаг 1800-1202 дугаарын утсаар, чатбот болон мессежбот үйлчилгээгээр дамжуулан 4500 гаруй иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Швейцарын хөгжлийн агентлаг, Азийн хөгжлийн банк, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан зэрэг байгууллагууд дэмжин ажиллав.

Үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг тус зөвлөлийн нарийн бичгийн дарга, ХЗҮХ-ийн захирал, доктор Х.Эрдэм-Ундрах танилцуулав. Хуралдааны төгсгөлд Үндэсний зөвлөлийн гишүүд хөтөлбөрийн сүүлийн жилд анхаарч ажиллах асуудлуудаа зөвшилцөж, цаашид гишүүн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах замаар хөтөлбөрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх нь чухал гэдэгтэй санал нэгдлээ.

Үндэсний зөвлөлийн даргаас гишүүдэд хандаж, эрх зүйн мэдлэг, мэдээллийг бага наснаас нь эхлэн олгох, мэдээллийн усргалын уялдаа холбоог сайжруулахаас гадна шинэлэг санал, санаачилга гаргахад онцгой анхаарч бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж ажиллах чиг үүрэг өглөө.





Хууль зүйн мэдээ
Улсын бүртгэлийн дугаар 1197
Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1, Хууль зүйн үндэсний хүрээлэн.
11-315789
www.nli.gov.mn
Бэлтгэсэн Ц.Энхжин




## ГАДААД ХАРИЛЦАА

Япон Улсын Сургалт судалгааны төвтэй хамтран 2 удаагийн workshop зохион байгуулж, 2023 онд судлаач мэргэшүүлэх сургалтыг хамтран зохион байгуулахаар болов.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Хууль тогтоомж, эрх зүйн мэдээллийн хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулах зөвшөөрөл авав.

БНСУ-ын Кукмин Их Сургуулийн Хууль зүйн сургуультай хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг зохион байгуулж, 2023 онд зочин судлаач илгээхээр харилцан тохиролцов.

Монгол Улс дахь КОЙКА-гийн суурин төлөөлөгчийг хүлээн авч хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

БНСУ-ын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэнтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулах зөвшөөрөл авч 2023 онд санамж бичиг байгуулахаар харилцан тохиролцов.

## ТООН МЭДЭЭЛЭЛ

65

хуулийн орчуулгыг www.legalinfo.mn цахим хуудсанд байршуулав

680

эрх зүйн актыг www.legalinfo.mn цахим хуудсанд хугацаанд

913

Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн захиалгын тоо

## E-KHUTUCH.mn

www.e-khutuch.mn цахим хуудасны "Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн хөтөч хуудас"-ны 54 бүлгийн мэдээллийг тогтмол шинэчилж байна.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн www.e-khutuch.mn цахим хуудаст 50-н мэдээ, мэдээлэл нийтэлж олон нийтэд түгээсэн.

Эрх зүйн хөтөч аппликейшнийг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн.

4500 гаруй иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаар, чатбот, мессежбот үйлчилгээгээр мэдээлэл өгсөн

778 эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалтад хамрагдсан.

Эрх зүйн хөтчийг давтан сургах сургалтын цахим платформд 16 сэдвээр 24 цагийн хичээлийн агуулга бэлтгэн оруулсан.

ИРГЭН ТАНД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙГ ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР ХҮРГЭХ УТАС:

08:30-17:30

# 1800-1202

Эрх зүйн боловсролыг иргэн бүрд